

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ, ТҮҮНИЙ АЖЛЫН АЛБАНЫ 2014 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ Б И Е Л Э Л Т**

2014.11.15

№	Хэрэгжүүлэх ажил/арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн	Биелэлт	
1	Авлигын эсрэг үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах	2014 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Авлигатай тэмцэх газарт хүргүүлэх	2014.02.28-ны өдрийн дотор	Д.Баатарсайхан	Авлигын эсрэг үйл ажиллагааны байгууллагын төлөвлөгөөг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн даргаар 2014 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталуулан Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 265 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн бөгөөд үйл ажиллагаагаа уг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж, төлөвлөгөөнд туссан үйл ажиллагааг зохион байгуулахад мэргэшил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллаа.
		Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах	Жилдээ	Д.Баатарсайхан	
		Тайлан, нотлох баримтыг бэлтгэн хүргүүлэх	2014.11.15	Д.Баатарсайхан	
		Байгууллагын албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг хугацаанд нь авч хяналт хийн Авлигатай тэмцэх газарт хуулийн хугацаанд хүргүүлж мэдээлэх, үүнтэй холбогдсон бусад үйлчилгээ үзүүлэх	2014.03.01 тухай бүр	Д.Баатарсайхан	Тайлан хүргүүлэх тухай Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 224 тоот албан бичгээр Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хуульд заасны дагуу Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооны 2012 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар тогтоолоор батлагдсан журам, мэдүүлэг, мэдэгдлийн маягт, цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажлын тайланг ХАСХОМ1, ХАСХОМ2 маягтаар 2013 оны байдлаар гарган нийт 13 албан хаагчийн мэдээг үүгээр хүргүүлж ажилласан бөгөөд Төрийн албаны зөвлөлийн хэмжээнд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн чиглэлээр зөрчил, маргаантай асуудал гараагүй бөгөөд 2014 онд томилогдсон 13 албан хаагч байгаа болно.
2.	Авлигын эсрэг хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх талаар ажилтнуудад болон сонгон шалгаруулалтанд өрсөлдөж буй иргэдэд танилцуулга өгөх	Жилдээ	Д.Баатарсайхан	Төрийн албаны зөвлөлийн албан хаагчид болон төрийн жинхэнэ албаны удирдах гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтанд өрсөлдөхөөр ирж шалгалтын бүртгэлд хамрагдаж буй иргэд, үйлчлүүлэгч нарт Авлигатай тэмцэх газраас 2012 онд бэлтгэн гаргасан "Хөрөнгө орлогын мэдүүлгийн маягтыг бөглөх зөвлөмж", "Хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргагч танаа" гарын авлагаас өгч авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор танилцуулахын зэрэгцээ төрийн жинхэнэ албан тушаалд томилогдохоор нэр дэвшүүлсэн албан бичиг тус бүрт "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 23 дугаар зүйлийн 23.5-д заасан шаардлага, нэр дэвшигчийн их, дээд сургууль төгссөн дипломын хүчинтэй эсэх, Эрүүгийн хуульд заасан онц хүнд болон бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж байсан эсэх талаарх лавлагаа, эрүүл мэндийн байдлын талаар нь магадлан итгэмжлэгдсэн эмнэлэгийн байгууллагын дүгнэлт, улс төрийн намын гишүүн бол Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу намын гишүүнчлэлээсээ түдгэлзсэн тухай баримт бичиг зэргийг холбогдох байгууллагуудаас нь албан ёсоор авч нэр дэвшигчийг томиллох" талаар мэдэгдэл хүргүүлэн ажилласан болно.	
	Ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах талаар аппаратын албан хаагчиддаа сургалт, семинар зохион байгуулах	2014 оны 2 сард	Д.Баатарсайхан	2014 оны 02 дугаар сард Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ахлах ажилтан н.Мөнхжаргалаар "Ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх, мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах" талаар ярилцлага, мэдээллийн цаг хийж албан хаагчидтайгаа уулзуулж мэргэшил арга зүйн зөвлөгөө, сургалт авч ажилласан. "Авлига ашиг, сонирхлын зөрчил ба ил тод байдал" сургалтыг Авлигатай тэмцэх газраас зохион байгууллаа. Сургалтаар авилгын гэмт хэрэг, авлигын болон ашиг сонирхлын зөрчил, хувийн, нийтийн ашиг сонирхлын тухай лекц сонсохын зэрэгцээ, авлигаас хэрхэн урьдчилан сэргийлэх, түүнд өртөхгүй байх талаар харилцан ярилцаж, санал бодлоо солилцлоо. Мөн Авлигатай тэмцэх газар НҮБ-ын "Иргэдийн оролцоотой хууль тогтоох ажиллагааг дэмжих нь" төслийн хүрээнд зохион байгуулагдсан НҮБ-ын Конвенцийн II, Y дугаар бүлгийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг үнэлэх зөвлөх үйлчилгээний тайланд судалгааны багаас дэвшүүлсэн зөвлөлийн талаарх хэлэлцүүлэг, 2014 оны 10 дугаар сард зохион байгуулсан "Ил тод, нээлттэй байдал ба авлигын эрсдэл хэлэлцүүлэгт тус тус оролцож санал бодлоо илэрхийлсэн.	

		Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөлийн дүгнэлт, саналгүйгээр томилогдох явдлыг таслан зогсоох үүднээс Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажлыг хийж гүйцэтгэх	2014 оны 1 дүгээр улиралд	Д.Баатарсайхан	Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд Төрийн албаны зөвлөл, түүний салбар зөвлөлийн дүгнэлт, саналгүйгээр томилогдох явдлыг таслан зогсоох үүднээс Авлигатай тэмцэх газартай хамтран ажиллах санамж бичиг байгуулах ажил хийгдэж амжаагүй ч 2014 оны 3 дугаар улирлаас эхлэн энэ ажлын эхлэл тавигдаж төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт, сонгон шалгаруулалтанд ороогүйгээр төсвийн шууд захиргач, томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтны саналаар томилоо хийх гэсэн оролдлогыг тодорхой хэмжээгээр зогсоож чадсан. Тухайлбал, Татварын ерөнхий газрын дэд даргын албан тушаал, Дорнод аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн албан хаагчид, Баян-Өлгий аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн дарга, Ус, цаг уур, орчны шинжилгээний газрын хэлтсийн даргад томилогдох албан тушаалтныг буцаасан зэрэг жишээ байгаа болно.
3	Салбарын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг цахим хуудсанд байршуулах, жагсаалтыг АТГ-т хүргүүлэх /хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бүх дүрэм, журмыг нэрээр нь байршуулах ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх/	Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд батлан гаргасан журам, дүрэм, зааврыг цахим хаягтаа байршуулж, өөрчлөлтийг тусгаж байх	2014.03.20-ны дотор	Д.Баатарсайхан М.Алтанбагана	Хил хамгаалах байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай 2014.01.24-ний өдрийн Төрийн албаны зөвлөлийн тогтоолоор 8, "Дипломат албаны төрийн тусгай албан тушаалд анх орох иргэнээс мэргэшлийн шалгалт авах журам батлах тухай" 2014.01.30-ны өдрийн 12, "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам"-д өөрчлөлт оруулах тухай" 2014.02.27-ны өдрийн 22, "Тахарын албаны төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай" 2014.03.30-ны өдрийн 33, "Гаалийн байгууллагын төрийн тусгай албан тушаалд ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай" 2014.04.04-ний өдрийн 43, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай" 2014.06.016-ны өдрийн 72, "Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын төрийн тусгай албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам, заавар батлах тухай" 2014.06.16-ны өдрийн 73, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2014.10.29-ний өдрийн 127 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д өөрчлөлт, "Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 20014.11.03-ны өдрийн 130 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журамд нэмэлт өөрчлөлтийг энэ онд оруулан шийдвэрлэж нийтээр дагаж мөрдүүлэхээр төрийн холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажиллаа.
		Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах журмыг боловсруулан Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд оруулж, шийдвэрлүүлэх	2014 оны 4 дүгээр улиралд	Т.Сосорбарам	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар батлах ажлын хүрээнд уг ажилд хийгдээгүй боловч одоогийн төрийн албанд мөрдөгдөж буй журмаар энэхүү асуудлыг зохицуулж байгаа болно. Удирдлагын академаар төрийн албан хаагчийг сэлгэн ажиллуулж буй өнөөгийн байдал цаашид ямар журмаар зохицуулах талаар судалгаа хийлгэсэн.
		Ажлын байрны тодорхойлолт боловсруулах заавар, загварыг шинэчлэн боловсруулж, Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд оруулж батлуулах	2014 оны 2 дугаар улиралд	С.Цэдэндамба Ажлын хэсэг	Ажлын албаны даргын 2014 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 23 дугаар тушаалаар ажилтнуудын ажил үүргийн хуваарийн дагуу ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах Ажлын хэсгийг ахлах референт Д.Баатарсайхан, шинжээч Г.Эрдэнэчимэг, зөвлөх ажилтан Х.Шаандар нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулагдан, 13 ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулав. Энэхүү журмыг шинэчлэн боловсруулж батлуулах нөхцөл бүрдээгүй боловч БНСУ-ын "DACUM" арга зүйг тус улсад судлан үзсэн болно. Мөн дараах зохицуулалтын хүрээнд сургалт зохион байгуулав. Үүнд: 1.Төрийн албаны тухай хууль: 14.1.1, 23.1.1, 10.5, 2.Хөдөлмөрийн тухай хууль: -21.1.2, 48.3.2, 51.1, 3.Төрийн албаны зөвлөлийн 2004 оны 34-р тогтоол, Улсын Их Хурлын 2003 оны 13-р тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам", Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86-р тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам"
		Удирдах ажилтны сонгон шалгаруулалтаар нөөцөд бүртгэх журам боловсруулах	2014 оны 4 дүгээр улиралд	Д.Баатарсайхан	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар зохицуулах ажлын хүрээнд уг ажилд хийгдээгүй боловч Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-ын 39, 40 дүгээр зүйлд зааснаар нөөцөд бүртгэгдэх үйл ажилгаа хийгдэж, нөөцөөс төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх үйл ажиллагаа хийгдэж байна.

		ТАЗ-ийн Ажлын албаны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулах,	2014 оны 1 дүгээр улиралд	Н.Энхцэцэг Г.Эрдэнэчимэг	"Ажлын албаны дүрэм, журам батлах тухай" Төрийн албаны зөвлөлийн даргын 2014 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн 43 дугаар тогтоолоор "Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дүрэм", "Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны хөдөлмөрийн дотоод журам" шинэчлэн баталж мөрдүүлсэн.
4	Шинээр боловсруулж буй хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг олон нийт, сонирхогч бүлгээр хэлэлцүүлэх, тэдний саналыг тусгах	Төрийн албан хаагчийн Хувийн хэрэг бүрдүүлэх журмын төслийг шинэчлэн боловсруулж ТАЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх	2014 оны 2 дугаар улиралд	М.Алтанбагана Н.Төмөрчөдөр	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар батлах ажлын хүрээнд уг ажил хийгдээгүй боловч одоогийн төрийн албнд мөрдөгдөж буй журмаар энэхүү асуудлыг зохицуулж байгаа болно.
		Тоо бүртгэл хөтлөх журмыг шинэчлэн боловсруулж, уг журмын төслийг ТАЗ-ийн хуралдаанаар хэлэлцүүлэх	2014 оны 3 дугаар улиралд	М.Алтанбагана Н.Төмөрчөдөр	Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгаар батлах ажлын хүрээнд уг ажил хийгдээгүй боловч одоогийн төрийн албнд мөрдөгдөж буй журмаар энэхүү асуудлыг зохицуулж байгаа болно. Төрийн албаны зөвлөлийн даргын 2014 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 88 дугаар тушаалаар 2014 оны төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хэрхэн үр дүнтэй, бодитой авах санал боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.
		Салбар зөвлөлийн үйл ажиллагааг үнэлж дүгнэх (ахиц дэвшлийн тайлан-үр дүнг үнэлж дүгнэх олон улсын жишигт нийцүүлсэн) хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлалыг шинэчлэн боловсруулж, ТАЗ-ийн хуралдаанд оруулж, шийдвэр гаргуулах	2014 оны 2 дугаар улиралд	С.Цэдэндамба Ц.Насанжаргал	Төрийн албаны зөвлөлийн 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд "Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажлыг дүгнэх журам батлах тухай"-ыг төслийг хэлэлцүүлэн "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам", "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт"-ийн төслийг хэлэлцэж, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлан үйл ажиллагаанда мөрдлөг болгов.
		Мэдээлэл лавлагаа, зөвлөх үйлчилгээний журам боловсруулах (онлайн санал, утас ажиллуулах, олон нийттэй харилцах)	2014 оны 2 дугаар улиралд	С.Цэдэндамба Л.Эрдэнэчулуун	Төсөвт зардалтай холбоотойгоор энэ ажил хийгдээгүй болно. Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт Төрийн албаны зөвлөлийн фэйсбүүкийг нээж санал авч эргэх холбоо үүсгэж байна.
5	Төсвийн орлого, түүний зарцуулалтыг, гадаадын зээл тусламж, түүний хуваарилалтыг вебсайтад байршуулах	Байгууллагын 2014 оны төсвийн товчоо мэдээг байгууллагын цахим хаягт байршуулах	2014.01.10-ны дотор	Ю.Оюунжаргал, М.Алтанбагана	Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуульд заасан шаардлагын дагуу санхүүгийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн 1-10 сарын мэдээ, 2013 оны санхүүгийн аудитын тайлан, 2014 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааны тайлан, 2015 оны төсвийн төсөлийг веб сайтад ил тод байдлаар байршуулан ажиллаа.
		2014 оны төсвийн гүйцэтгэлийн мэдээг бэлтгэн цахим хаягт байршуулах	2014.04.01-ний дотор	Ю.Оюунжаргал, Н.Төмөрчөдөр	
		2015 оны төсвийн төслийг бэлтгэн Сангийн яаманд хүргүүлэх	2014.06.15-ны дотор	Ю.Оюунжаргал Э.Шинэ-Уянга	
		2013 оны санхүүгийн тайланг нийтэд мэдээлэх	2014.04.25-ний өдрийн дотор	Ю.Оюунжаргал Э.Шинэ-Уянга	
		2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт	2014.04.25-ний өдрийн дотор	Ю.Оюунжаргал Э.Шинэ-Уянга	
		2014 оны төсөвт өөрчлөлт орсон тохиолдолд тухайн бүр мэдээлэх	өөрчлөлт орсноос хойш 14 хоног	Ю.Оюунжаргал Э.Шинэ-Уянга	

<p>"Том төрөөс ухаалаг төр рүү" санаачлагын дагуу авах арга хэмжээний зөвлөмж боловсруулж, хяналт тавьж ажиллах</p>	<p>2014 оны 1 дүгээр улиралд</p>	<p>С.Цэдэндамба Д.Баатарсайхан</p>	<p>"Зөвлөмж хүргүүлэх тухай" Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 148 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлөөс 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр зохион байгуулсан "Ерөнхийлөгчийн санаачилсан "Том төрөөс ухаалаг төр рүү" санаачлагыг дэмжих, хэрэгжилтийг хангахад бидний манлайлал" сэдэвт хэлэлцүүлэгээс гарсан, Төрийн албаны зөвлөлийн 2014 оны анхдугаар хуралдаанаас дэмжсэн зөвлөмжийг хүргүүлж, Зөвлөмжид заасны дагуу өөрийн байгууллага, үйл ажиллагааны хүрээнд хамаарч буй төрийн байгууллагадаа ухаалаг төрийн зарчмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явц, үр дүнгийн үнэлгээ, тайлангаа заасан хугацаанд Төрийн албаны зөвлөлд ирүүлэхийг мэдэгдэх үүрэг өгсөн болно.</p> <p>"Том төрөөс ухаалаг төр рүү" санаачилгыг дэмжиж Салбар зөвлөлүүд, төрийн албан хаагчдаас төрийн албаны шинэтгэл, төрийн албаны хүний нөөцийн тогтолцоог боловсронгуй болгох талаар гаргасан саналыг нэгтгэн Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 28 дугаар хуралдаанд танилцуулав.</p> <p>Мөн "Хамтран ажиллах тухай" Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 48, 49, 51 тоот албан бичгүүдээр Хүний эрхийн үндэсний комисс, Авлигатай тэмцэх газар, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэн санал авч улмаар Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанд "Том төрөөс ухаалаг төр рүү" санаачлагын дагуу авах арга хэмжээний талаар төрийн байгууллага, албан хаагчдын үйл ажиллагаанд зориулан зөвлөмжийг хэлэлцүүлэн шийдвэрлүүлж Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 52 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн яам, агентлаг, аймаг, нийслэлийн дэргэдэх Салбар зөвлөлүүдэд хүргүүлэн ажилласан болно.</p> <p>"Ажлын хэсэг байгуулах тухай" Төрийн албаны зөвлөлийн даргын 2014 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн 67 дугаар тушаалаар "Том төрөөс ухаалаг төр рүү" санаачилгыг дэмжиж 2014 онд Салбар зөвлөлүүдийн хийсэн ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулагдсан.</p>
<p>ТАЗ-ийн цахим хуудсанд "Том төрөөс ухаалаг төр рүү" гэсэн булан нээх</p>	<p>2014 оны 1 дүгээр улиралд</p>	<p>Д.Баатарсайхан, М.Алтанбагана</p>	<p>Тодорхой булан нээж ажиллаагүй ч төрийн байгууллагуудаас "Том төрөөс ухаалаг төр рүү" сэдэвт ажлын дагуу хийж буй ажлын мэдээллийг хүлээн авч нэгтгэсэн болно.</p>
<p>ТАЗ-ийн цахим хуудсаар дамжуулан иргэдээс санал авах (эргэх холбоо үүсгэх) цонх үүсгэх</p>	<p>2014 оны 1 дүгээр улиралд</p>	<p>Д.Баатарсайхан, М.Алтанбагана</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн цахим хаягт Төрийн албаны зөвлөлийн фэйсбүүкийг нээж санал авч эргэх холбоо үүсгэж байна.</p>
<p>Хүйсийн харьцаа алдагдсан салбарын талаар судалгаа хийх</p>	<p>2014 оны 2 дугаар улиралд</p>	<p>С.Цэдэндамба, А.Цэцэгмаа</p>	<p>Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.1.2-т "төрийн захиргааны удирдах албан тушаалтны дотор аль нэг хүйсийн төлөөлөл яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргын 15 хувиас, бусад төв байгууллагын удирдлагын 20 хувиас, яамдын газар, хэлтсийн даргын 30 хувиас, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтэс, албадын даргын 40 хувиас доошгүй байх" гэсэн заалтыг удирдлага болгон ажиллаж байгаа бөгөөд Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлт, Улсын Их Хурлаас батлах журмын хүрээнд уг асуудлыг шийдвэрлүүлэхээр судалж буй болно.</p> <p>Жендэрийн үндэсний хороотой хамтран гаргасан судалгааг хавсралтаас үзэх.</p>
<p>Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран тухайн онд гэмт хэрэг зөрчилд өртсөн төрийн албан хаагчдын тоон мэдээллийг авах,</p>	<p>2014 оны 2, 4-р улирал</p>	<p>Г.Зоригтбаатар Ш.Эрдэнэбат</p>	<p>Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газартай хамтран тухайн онд гэмт хэрэг зөрчилд өртсөн төрийн албан хаагчдын тоон мэдээллийг авч төрийн албаны тухай хуулийн талаарх хэлэлцүүгийн үеэр Төрийн албаны зөвлөлийн удирдлагаас тавих илтгэлд тусган ажиллаа.</p>
<p>Төрийн албан хаагчийн эрх зөрчигдсөн байдал хууль хяналтын байгууллагаар хэрхэн шийдвэрлэгдсэн байдлын талаар тоон мэдээлэл авах</p>	<p>2014 оны 2, 4-р улирал</p>	<p>Г.Зоригтбаатар Ш.Эрдэнэбат</p>	

<p>Үр дүнгийн гэрээний журмыг боловсронгуй болгох санал боловсруулж Төрийн албаны зөвлөлийн хуралдаанд танилцуулах</p>	<p>2014 оны 1 дүгээр улиралд</p>	<p>Т.Сосорбарам</p>	<p>"Ажлын хэсэг байгуулах тухай" Төрийн албаны зөвлөлийн даргын 2014 оны 3 дугаар сарын 14-ний өдрийн 21 дүгээр тушаалаар "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам"-ыг боловсронгуй болгох үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан.</p> <p>Төрийн албаны зөвлөлийн 2012 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 134 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин (Үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэх)-г үнэлж дүгнэх журам"-ыг шинэчлэн боловсруулсан журмын төслийг боловсруулсан болно. Уг төсөлд: Үр дүнгийн гэрээний үнэлгээг бодитой хийдэг болгох, цалин хөлс, урамшуулалтай холбох, бүх албан хаагчид хавтгайдаа А, В үнэлгээ авдгийг болиулах зэрэг санал, шүүмжлэл нэлээд гарах болсон той холбоотойгоор ажлын хэсэг гадаад орнуудын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, Монгол Улс дах гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын гүйцэтгэлийн удирдлагын тогтолцоо, төрийн болон орон нутгийн байгууллагуудад төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг хэрхэн үнэлж байгаа, өмнөх онуудын үр дүнгийн гэрээг дүгнэсэн байдал зэргийг судлан үзэж журмын төслийг боловсруулав.</p> <p>Мөн 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 680 тоот албан бичгээр Төрийн албаны зөвлөлийн нийт салбар зөвлөлүүд, УИХ-д ажлаа тайлагнадаг нийт гэх зэрэг нийт 60 байгууллагаас журмын төсөлд санал авав. Үүнээс 49 байгууллагаас журмын төсөл, төслийн хавсралтуудад санал ирүүлснийг ажлын хэсгээр ярилцаж судалж үзэн, тусгах боломжтой саналыг журмын төсөлд тусгав. Үүнээс давхардсан тоогоор 18 байгууллага төслийг бүхэлд нь дэмжсэн болон тусгайлан өгөх саналгүй, 1 байгууллага тогтоолын төсөлд 1 санал, 30 байгууллага журмын төсөлд 179 санал, 3 байгууллага дүгнэх хуудасны загварт 7 санал, 6 байгууллага гэрээг дүгнэх аргачлалд 10 санал тус тус ирүүлсэн. Энэхүү журмын иеслөөр төрийн зарим байгууллагуудад туршилтын үнэлгээ хийлгэхээр шийдвэрлэж ажиллаж байгаа бөгөөд эхний байгууллагууд дүнгээ ирүүлээд байна.</p>
<p>Төрийн албаны удирдах ажилтны манлайлах үр чадварыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулах, зохицуулах.</p>	<p>Жилдээ</p>	<p>Л.Эрдэнэчулуун</p>	<p>батлан гаргаж "Богино хугацааны мэргэшүүлэх сургалт", "Захиалгат болон зорилтот сургалт", "ажлын байран дээр болон зайн сургалт"-ыг тус тус зохион байгуулав. Үүнд:</p> <p>Төрийн албаны Институт нь тасралтгүй өөрчлөгдөн шинэчлэгдэж байгаа орчинд идэвхи, бүтээлч санаачлага, хариуцлагатай, үр дүнг эрхэмлэн дээдэлж манлайлан ажиллах чадавхи сайтай төрийн байгууллага болон төрийн албан хаагчийг төлөвшүүлэх зорилгоор захиалгат сургалтуудыг зохион байгуулсан. Байгууллага хамт олон, албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийн хүрээнд 2014 оны эхний хагас жилийн байдлаар дараах төрийн байгууллагуудын албан хаагчдад "Төрийн алба түүний мөн чанар, Үр дүнгийн гэрээ, Төрийн албаны хүний нөөцийн удирдлагатай холбоотой гарах баримт бичиг, Төрийн албан хаагчийн хувийн хэргийн хөтлөлт, арга зүй, Төрийн албаны шинэтгэлийн бодлого, Төрийн албан хаагчын ёс зүй, Төрийн захиргааны албан хаагчын ёс зүй, Төрийн албан хаагчийн харилцааны соёл, Зөрчлийн удирдлага" зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж доорх байгууллагууд хамрагдлаа. Үүнд: Хүний эрхийн үндэсний комиссын Ажлын алба, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Орхон аймаг Засаг даргын тамгын газар, Зэвсэгт хүчний 0310 дугаар анги, Хан-Уул дүүргийн Засаг даргын тамгын газар, Налайх дүүргийн Засаг даргын тамгын газар, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол нутгийн удирдлагын холбоо, Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба, Хөрөнгө оруулалтын газар, Налайх дүүргийн Хөдөлмөрийн хэлтэс, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс, Боловсрол, шинжлэх ухааны яам, Эрүүл мэндийн яам, уянт-Ухаа Хилийн мэргэжлийн хяналтын газар, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газар тус тус хамрагдлаа.</p> <p>Төрийн албаны Институт нь төрийн албан хаагчдын мэдлэг, мэргэшил, үр чадварыг дээшлүүлж чадавхийг нь</p>

<p>Төрийн жинхэнэ албан хаагчийн зорилтот (ёс зүй, манлайлал, гүйцэтгэлийн менежмент г.м) сэдэвчилсэн сургалтыг зохион байгуулах</p>	<p>Тухай бүр</p>	<p>Л.Эрдэнэчулуун</p>	<p>Төрийн албаны үнэттүг нь төрийн албан хаагчид төдийгүй, төрөөсний үр төдөрөөр дөвшүүлж, төдийгүй нь сайжруулах үүднээс зорилтот бүлгүүдэд чиглэсэн практик арга зүйн сертификат олгох сургалтын хөтөлбөрүүдийн хүрээнд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан тушаалын туслах, дэс, ахлах, түшмэлийн модуль гэрчилгээ олгох сургалт 2014 оны 5 дугаар сар 5-7-ны өдрүүдэд зохион байгуулагдав.</p> <p>Сургалтад Сангийн яам, Гадаад харилцааны яам, Байгаль орчин, ногоон хөгжлийн яам, Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Зам тээврийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөрийн яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эрүүл мэндийн яам, Гаалийн ерөнхий газар, Төрийн өмчийн хороо, Үндэсний статистикийн хороо, Тагнуулын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Иргэний нисэхийн ерөнхий газар, Худалдан авах ажиллагааны газар Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүд, Сүхбаатар аймгийн сумдын ЗДТГ зэрэг байгууллагуудын хүний нөөцийн асуудал эрхэлсэн 117 төрийн албан хаагчид хамрагдаж гэрчилгээ авлаа.</p> <p>Төрийн албаны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулж байгаа Төрийн албаны тухай хууль тогтоомжид төрийн албан хаагчид нь тухайн албан тушаалдаа ажилласан жил, ажлын үр дүнгээс хамааран ангилал зэрэг ахих төдийгүй шаардлагатай мэдлэгийг олгох тодорхой үе шат бүхий зорилтот сургалтад хамрагдан гэрчилгээ авсан байх гэсэн шалгуурыг хангах тухай тусгагдаж байгаа бөгөөд Төрийн албаны Институтээс зохион байгуулж байгаа энэхүү гэрчилгээ олгох сургалт нь уг шинэтгэлийн урьдач нөхцөл нь болж байгаа онцлогтой юм.</p>
<p>Төсвийн байгууллагын дарга эрхлэгчийг сонгон шалгаруулах журам, зааварт нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг судлах, журмыг баримтлан ажиллах талаар төрийн байгууллагад зөвлөгөө дэмжлэг үзүүлэх</p>	<p>Тухай бүр</p>	<p>Д.Баатарсайхан</p>	<p>"Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2014.10.29-ний өдрийн 127 дугаар тогтоолоор Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 60 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам"-д өөрчлөлт оруулав. Энэхүү өөрчлөлт нь: төрийн үйлчилгээний албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтын дүнг хэрхэн албажуулах, тайлан мэдээг хэрхэн хурдан мэдээлэх, нөөцийн асуудлыг бүрэн шийдвэрлэхийн зэрэгцээ маргаан гарсан тохиолдолд хаана, хэрхэн шийдвэрлүүлэхийг зохицуулсан болно.</p>
<p>Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын үйл явцыг цахимжуулах арга зүйг боловсруулах, хэрэгжүүлэх, энэ чиглэлээр зөвлөгөө арга зүйн дэмжлэг үзүүлэх</p>	<p>Тухай бүр</p>	<p>Д.Баатарсайхан</p>	<p>Төрийн албаны зөвлөлийн Статистикийн ерөнхий газрын дэргэдэх болон Шүүхийн ерөнхий зөвлөл, яам, агентлаг, аймаг нийслэлийн дэргэдэх салбар зөвлөлүүд, орон нутгийн Боловсролын газарт төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрт шилжүүлэх чиглэлээр 2014 оны 10 дугаар Төрийн албаны зөвлөлийн албан бичиг хүргүүлэн үүний үр дүнд улсын хэмжээн дэх төрийн албаны удирдах ажилтны сонгон шалгаруулал цахим хэлбэрт шилжин ажиллаж байна. Мөн тэрчлэн нийгмийн даатгалын салбарын улсын байцаагчийн эрх олгох шалгалтыг Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, Нийгмийн даатгалын ерөнхий газартай хамтран зохион байгуулсан нь илүү үр дүнтэй боллоо.</p>
<p>Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын төстийн санг баяжуулах /хүчингүй болсон, нэмэлт өөрчлөлт орсон хуулийн төстүүдийг хасах, шинэчлэх/</p>	<p>Жилдээ</p>	<p>Т.Сосорбарам</p>	<p>2015 онд "Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын сорилгын хураамж"-ийн хүчингүй болсон, эргэлзээтэй төстүүдийг хасч, хэвлэлтэнд өгөх бэлтгэл ажил хийгдэж эхлээд байгаа бөгөөд 2015 оны сорилын гарын авлагын эхний хувилбар бэлтгэгдсэн болно.</p>
<p>Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх ажилтны сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн захиалгын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлэх</p>	<p>Жилдээ</p>	<p>Т.Сосорбарам М.Алтанбагана</p>	<p>Төрийн жинхэнэ албаны гүйцэтгэх ажилтны сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн захиалгын дагуу зохион байгуулж, хэрэгжүүлж байгаа бөгөөд энэхүү шалгалтын захиалга, зар мэдээг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд бүрэн дүүрэн мэдээлж шалгалтын үнэлгээтэй холбоотой маргаан, гомдол гарах явдал байхгүй болсон. Мөн шалгалтыг ил тод зохион байгуулах үүднээс шалгалт зохион байгуулдаг танхимд 4 ширхэг камер байршуулан шалгалтын гадна хананд дэлгэцээр хангалт хийв. энэ нь дотор шалгалт өгч буй иргэдийг гаднаас хянах, үйл ажиллагааг нь нээлттэй байлгахад үр нөлөөг өгч байгаа юм.</p>

<p>Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэнийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, нөөцийн сан бүрдүүлэх, уг сангийн мэдээллээр сонирхогч байгууллагад үйлчилгээ үзүүлэх</p>	<p>Жилдээ</p>	<p>Т.Сосорбарам Ц.Галбадрах</p>	<p>Төрийн захиргааны төв байгуулага, агентлаг, Улсын Их Хурлаас удирдлага нь томилогддог байгууллагын захиалга хүсэлтийн дагуу нөөцийн жагсаалтаас нэр дэвшүүлэх асуудлыг журмын дагуу зохион байгуулж байна. 2014 онд нийтдээ давхардсан тоогоор төрийн захиргааны төв байгууллагад 113 ажлын байранд 979 иргэн бүртгүүлж 306, нийслэлд 75 ажлын байранд 20155 иргэн бүртгүүлж, 511 иргэд, 21 аймагт 1044 ажлын байранд 5003 иргэн бүртгүүлж 1174 иргэн тэнцсэн бөгөөд нийтдээ 1232 ажлын байранд 8137 иргэн бүртгэлд хамрагдан 1991 иргэн тэнцэн нөөцөд бүртгэгдсэн бөгөөд эдгээрээс төрийн холбогдох байгууллагын зохих албан тушаалд нэр дэвшүүлэн томилуулаад байна. Төрийн жинхэнэ албаны нөцөөс Улсын Их Хурлын байгууллагуудад 36, яамдад 68, Засгийн газрын агентлагт 52, бусад төрийн байгууллагуудад 12 нийтдээ 168 албан тушаалын сул орон тоог нөхүүлэхээр Төрийн албаны зөвлөлөөс нэр дэвшүүлэв.</p>
